

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## 1 Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан .....	4
	2.1. Оршил .....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
	2.8.1 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	7
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	10
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал.....	12
	3.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал.....	12
	3.1.1 Илрүүлэлт: .....	12
	3.1.2 Эрсдэл: .....	12
	3.1.3 Өгсөн зөвлөмж:.....	13
	3.2.2 Эрсдэл: .....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
	4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	14
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	15
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан .....	17
	4.5 Аудит хийсэн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт.....	19
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

“ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН  
СТАНЦ” ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Б.ОТГОНСҮХ ТАНАА

2019.04.01 № 06/648  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


#### Үүрэг, хариуцлага

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

071764

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус компанийн захирал Б.Отгонсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 15-аас 2019 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Ниямазон аудит” ХХК-ийн аудитын менежер Ж. Батнасан, бүртгэлийн мэргэжилтэн Ж. Ариунаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК нь 2018 оны санхүүгийн тайлангаа “Ниямазон аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 01/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 132 дугаар тогтоолоор баталсан тус компанийн дүрмэнд зорилгыг “Эгийн голын усан цахилгаан станцын төслийг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлж, түлхүүр гардуулах нөхцөлөөр станцыг барьж ашиглалтад оруулж, Монгол Улсын эрчим хүчний системийн бие даасан байдлыг ханган, үүсгүүр хүчин чадлын бүтцийг өөрчлөн сайжруулж, тогтвортой ажиллагааг нь дээшлүүлэн аваарын болон нөөцийн хүчин чадалтай, оргил ачааллын горим тохируулгын найдвартай ажиллагааг бүрэн хангахад оршино” хэмээн тодорхойлжээ.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, бусад техникийн баримт бичгийг боловсруулах;
- байгаль орчин, нийгмийн нөлөөлийн болон бусад судалгааны ажлыг хийж гүйцэтгэх;
- санхүүжилтийн нөхцөлийг тодорхойлж шийдвэрлүүлэх, санхүүжилтийн эргэн төлөлтийг хариуцах;
- барилгын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэж, хяналт тавьж, ашиглалтад оруулах;
- үйл ажиллагааг эрхлэн явуулж, цахилгаан үйлдвэрлэн төвийн эрчим хүчний нэгдсэн системд нийлүүлэх.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Компанийн тухай хууль
- Татварын болон нийгмийн даатгалын багц хуулиуд

Засгийн газрын 2018 оны 335 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-д өөрчлөлт оруулан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийг төлөөлөх этгээдийг томилж, чөлөөлнө” гэсэн заалтыг нэмсэн байна.

Дээрх заалтаар тус компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бус Эрчим хүчний яам хэрэгжүүлэх болсон байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Эрхэт” онлайн програм хангамж ашигладаг байна.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд компани ашгийн төлөө байгууллага боловч үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан орлого олдоггүй, Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр санхүүждэг, төсөл хэрэгжснээс хойш хугацаанд гарсан зардлыг урьдчилж төлсөн зардал дансанд хуримтлуулан бүртгэсэн тул цэвэр хөрөнгийн дүнг суурь болгон авлаа.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийн дүн 18,635.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 186.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг цэвэр хөрөнгийн дүнгийн 0,2 хувиар тооцон гаргасан боловч гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг хамгийн багаар тогтоосон нь аудитын үйл ажиллагааг илүү нарийн, үр ашиггүй болгоно гэж үзсэн тул 1 хувь болгон өөрчиллөө.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.1 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(сая төгрөгөөр)

	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	25.7	
2	Төлбөрийн акт	1	2.5	
3	Албан шаардлага	2	101.0	
	Дүн	5	129.2	



## **2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **Асуудал 1: Зардлын талаар**

Тус компанийн 4 ажилтан 2018 оны 9-р сарын 26-наас 10-р сарын 4-ний хооронд Дани улсад “Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх” олон улсын 7 дугаар бага хуралд оролцоходоо захирлын А/27 дугаар тушаалд заасан хугацааг зөрчиж, зам хоногийн зардлыг 1.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

#### **Шийдэл:**

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Тушаалд заасан хугацааг зөрчиж зарцуулсан зам хоногийн зардал 1.5 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### **Асуудал 2: Бараа материалын талаар**

Бараа материалын тайланд 2018 оны 6-р сарын 11-нд 1.0 сая төгрөгөөр принтерийн хор худалдан авсан хүчин төгөлдөр бус баримт хавсаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог хэлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

#### **Шийдэл:**

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Хүчин төгөлдөр бус баримттай тул 1.0 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### **Асуудал 3: Мөнгөн хөрөнгийн талаар**

2018 оны жилийн эцсийн байдлаар 66.5 сая төгрөгийн үлдэгдэл кассанд бүртгэлтэй байсан боловч тооллого үйлдээгүй, мөнгөн кассын ажиллагааны журам батлуулж мөрдөөгүй байна. Энэ нь Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн “Бэлэн мөнгөний орлого хүлээн авах, зарцуулалт хийх, хяналт тавих, хадгалах хамгаалахад тусгай журмаар зохицуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

#### **Шийдэл:**

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Байгууллагын онцлогт тохируулан жижиг мөнгөн сангийн журам баталж мөрдөх, жижиг мөнгөн сангийн лимитээс хэтэрсэн бэлэн мөнгийг өдөрт нь тушааж байх албан шаардлага өгөх.

### **Асуудал 4: Томилолтын тооцооны талаар**

34.5 сая төгрөгийн томилолтын урьдчилгааны тооцоог хийгээгүй, мөнгөн урьдчилгааны тайланг бэлтгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын “Маягт заавар батлах тухай” 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтанд “Мөнгөн урьдчилгааны тайлан нь САГ-2019/94/СТА-ТӨҮГ

гадаад, дотоод томилолт, хангамжийн урьдчилгаа гэх мэт бүх төрлийн мөнгөн урьдчилгааны гүйцэтгэлийг тайлагнах үндсэн баримт юм. ... үлдэгдэл буюу илүү зарцуулсан дүнгийн талаар орлого, зарлагын хэддүгээр баримтаар орлого, эсвэл зардал болгосон шийдвэрийг тэмдэглэнэ. Энэ тэмдэглэлийг хянасан нягтлан бодогч үйлдэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

#### **Шийдэл:**

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

Мөнгөн урьдчилгааны тайланг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягтыг нөхөх заавар”-ын дагуу гаргаж хэвших албан шаардлага өгөх.

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

#### **2.9.1 Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар**

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын дагуу газар эзэмших үнэлгээг санхүүгийн тайлагналын зорилгоор “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн үнэлгээ хийх ажлын хэсэг гүйцэтгэн, “Пантермидланд аудит” ХХК-иар нягтлан шалгалт хийлгэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүлээлгэн өгсөн байна.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК нь 2018 онд үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээнд Орхон аймагт 2, Булган аймагт 5 нийт 7 эзэмших эрхийн гэрчилгээтэй газрыг хамруулсан байна. Үүнд:

- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан баг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хаягдлын аж ахуй руу салсан шороон замаас Зосын даваа хүртэлх 11.45 км урттай 1,104,600 м.кв автозамын трассын зориулалттай газар, “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК-иас Зосын даваа хүртэлх 11км урттай 695,200 м.кв цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын зориулалттай газар,
- Булган аймгийн Бугат сумын Баянцагааны овооноос Эг-Сэлэнгийн бэлчирт Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалттай 3,602,400 м.кв газар, Баянцагааны овооноос Эг-Сэлэнгийн бэлчирт 5,776,000 м.кв автозамын трассын зориулалттай газар,
- Булган аймгийн Сэлэнгэ сумын 1-р баг Алаг морьтын дэнжид автозамын зориулалттай 299,000 м.кв газар, Алаг морьтын дэнжид шугам сүлжээний зориулалттай 158,000 м.кв газар, автозамын үйлдвэрлэлийн зориулалттай 12,000 м.кв газар нийт 7 газрын эзэмших эрхийг үнэлгээнд хамруулсан.

Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтанд заасан Орхон аймгийн Баян-Өндөр сум, хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл-ангиллын 5 дугаар бүсийн 1 га газрын суурь үнэлгээнд үндэслэн 1 м.кв газрыг 1600 төгрөг, 6 дугаар хавсралтанд заасан Бусад сумын төвийн газрын 1 га газрын суурь үнэлгээнд үндэслэн 1 м.кв газрыг 1600 төгрөгөөр тооцож 7 газрыг тус тус үнэлэн биет бус хөрөнгө/газар эзэмших эрх болон өмчийн бусад хэсэг дансыг 18,635.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж бүртгэсэн байна.

#### **2.9.2 Бэлэн мөнгөний их хэмжээний үлдэгдлийн талаар**

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК нь санхүүгийн тайлангаар жилийн эцэст их хэмжээний бэлэн мөнгөний үлдэгдэл тайлагнасан бөгөөд аудитын шаардлагаар 2019 оны 3-р сарын 16-нд компанийн харилцах дансанд тушаасан. Тус компани кассын үлдэгдэл хангалттай байхад харилцах данснаас бэлэн мөнгө их хэмжээгээр авсан,

тайлант хугацаанд бэлэн мөнгөний үлдэгдлийг огт тоолж, баталгаажуулаагүй, кассын журам баталж мөрдөөгүй учир бэлэн мөнгөний хувьд эрсдэлтэй байна.

### **2.9.3 Цалингийн 100 хувийн нэмэгдлийн талаар**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн захиралтай 2018 онд байгуулсан контрактанд компанийн цалингийн фондыг 1,017.4 сая төгрөгөөр баталсан байна. Гэвч Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй тус компанийн хувьд цалингийн нэмэгдлийг бүх ажилтанд 50-100 хувь хавтгайруулан олгож буй зүй зохисгүй байдал ажиглагдлаа.

### **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 683 дугаар тогтоолоор “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төсвийг баталж, 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 188 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Компанийн урсгал зардлыг 1,512.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 35.0 сая төгрөгөөр, зөвлөх үйлчилгээний зардлыг 1,500.0 сая төгрөгөөр, дотоод гэрээт ажлын төлбөрийг 136.0 сая төгрөгөөр нийт 3,183.8 сая төгрөгийн төсөв баталжээ.

Гүйцэтгэлээр нийт зардлыг 1,675.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь Эгийн голын усан цахилгаан станц төслийн Сэлэнгэ мөрөн, Байгал нуурын биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийн судалгааны ажлыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтаар шаардлага хангасан гүйцэтгэгч ирээгүйн улмаас зөвлөх үйлчилгээ аваагүйтэй холбоотой байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn сайтад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар 1, үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө зарцуулах шийдвэрийн 20, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн 1 мэдээлэл оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 67 хувьтай байна. Өмнөх аудитаар 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгснөөс 2 зөвлөмж биелсэн, урьдчилж төлсөн зардалд 15.0 сая төгрөгөөр бүртгэсэн, "Вивид технологи" ХХК-тай холбоотой и- оффис, нягтлан бодох бүртгэлийн програмын асуудлыг шийдвэрлэж компанийг хохиролгүй болгоогүй учир албан шаардлага биелээгүй байна. Энэ асуудлыг зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэх асуудалд тусгасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

1. Тус компанийн нягтлан бодогч 2018 оны 6-р сарын 11-нээс 9-р сарын 5-ны хооронд буюу 2 сар 24 хоногийн хугацаанд бэлэн мөнгөний нярвын ажлыг хавсарч гүйцэтгэсэн. Энэ нь Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн “Мөнгө хариуцагч ба нягтлан бодох бүртгэлд тусгах үүрэг хариуцлага нь тусдаа байна /Нярав, нягтлан бодогч хоёрын ажил үүрэг цуг байж болохгүй/” гэсэн заалттай нийцэхгүй байна.
2. Кассын зарлагын баримт, мөнгө олгохыг хүссэн өргөдөлд мөнгө хүлээн авсан, өргөдөл гаргасан гарын үсгийн бүрдэлгүй 10.7 сая төгрөгийн баримтыг бүртгэлд тусгасан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-т “Бэлэн мөнгө авах хүмүүс бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдлийг асуултын дагуу 1 хувь нөхөн бичиж, гарын үсгээ зурсны дараа дарга, ерөнхий нягтлан бодогчоор цохуулж, гарын үсэг зуруулан, бэлэн мөнгөний зарлагын баримт хавсаргахаар хариуцсан нягтлан бодогчид өгч, нярваас мөнгөө авч, баримтын 1 хувийг няравт үлдээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Мөнгөн хөрөнгийг бүртгэх үйл ажиллагааг мөнгөн хөрөнгийг зарлагадах ажлаас тусад нь зохион байгуулах зарчмыг алдагдуулсан.

Мөнгөн хөрөнгөнд тавих хяналтыг сулруулах, байгууллагын хөрөнгийг хувийн зорилгоор ашиглах нөхцөл, боломжийг бүрдүүлэх эрсдэлтэй.

### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

1. Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хүрээнд компанийн онцлогийг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын “Мөнгө хариуцагч ба нягтлан бодох бүртгэлд тусгах үүрэг хариуцлага нь тусдаа байна /Нярав, нягтлан бодогч хоёрын ажил үүрэг цуг байж болохгүй” гэсэн заалтыг мөрдөж ажиллах,

2. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж ажиллах.

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар**

Зөвлөмжийг биелүүлж ажиллана.

#### **3.2.1 Өмнөх аудитын албан шаардлагын хэрэгжилт**

Тус компани Үндэсний аудитын газарт 2018 оны 7-р сарын 10-нд 01/128 тоот албан бичгээр аудитын зөвлөмжийн биелэлтийг хүргүүлсэн бөгөөд, хэрэгжилтийг шалгаж үзэхэд 2 зөвлөмж биелсэн байна.

Урьдчилж төлсөн зардалд 15.0 сая төгрөгөөр бүртгэсэн "Вивид технологи" ХХК-тай холбоотой и- оффис, нягтлан бодох бүртгэлийн гэх 2 програмын асуудлаар харилцан 3 удаа албан бичиг өгсөн, хурал хийж протокол хийсэн боловч асуудлыг эцэслэн шийдвэрлэж, компанийг хохиролгүй болгох тухай албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Байгууллагын өмч хөрөнгө, үрэгдэх

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Гэрээний үүргээ биелүүлээгүй “Вивид технологи” ХХК-тай холбоотой 15.0 сая төгрөгийн асуудлыг хуулийн байгууллагаар шийдүүлэх

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар**

Зөвлөмжийг биелүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	165,405,584.26	588,492,800.76
1.1.2	Дансны авлага	861,200.00	850,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	96,199.98	118,023.72
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	22,567,902.50	17,659,116.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11,247,861,725.71	11,246,318,417.79
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>11,436,792,612.45</b>	<b>11,853,438,358.77</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	255,447,019.26	284,897,512.11
1.2.2	Биет бус хөрөнгө	8,069,522.39	18,641,098,241.82
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>263,516,541.65</b>	<b>18,925,995,753.93</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,700,309,154.10</b>	<b>30,779,434,112.70</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	136,599,860.29	92,718,000.00
2.1.1.3	Татварын өр	19,434,644.67	341,023.60
2.1.1.6	Хүүний өглөг	617,709,172.28	
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>773,743,677.25</b>	<b>93,059,023.60</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		28,012,345,077.91
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	23,839,688,020.07	3,301,470,630.47
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>23,839,688,020.07</b>	<b>31,313,815,708.38</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>24,613,431,697.31</b>	<b>31,406,874,731.98</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:- төрийн		20,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг		18,635,520,000.00
2.3.4	Хуримтлагдсан ашиг	-12,913,122,543.21	-12,788,627,416.55
2.3.5	Тайлант үеийн ашиг		-6,474,353,202.73
<b>2.3.6</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>-12,913,122,543.21</b>	<b>-627,440,619.28</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,700,309,154.10</b>	<b>30,779,434,112.70</b>

#### 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>		
2	Борлуулалтын өртөг		
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>		
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	3,872,441.49	7,462,497.28
6	Борлуулалт, маркетингийн зардал	5,500,000.00	39,387,045.20
7	Ерөнхий ба удирдлагын зардал	926,760,287.31	1,384,765,063.49
8	Санхүүгийн зардал	975,090,932.70	2,438,484,587.30
9	Бусад зардал	23,824,260.00	59,364,587.47
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-35,764,088.15	-2,494,032,318.73
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-71,531,638.98	-65,035,848.10
12	Бусад ашиг ( алдагдал)	104.105.00	
<b>13</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-2,070,494,660.65</b>	<b>-6,473,606,953.01</b>
14	Орлогын татварын зардал	345,197.69	746,249.72
<b>15</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-2,070,839,858.34	-6,474,353,202.73
17	Орлогын нийт дүн	-2,070,839,858.34	-6,474,353,202.73
18	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



### 4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			10,585,636,095.23	10,859,636,095.23
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			17,353,410.36	17,353,410.36
3	Залруулсан үлдэгдэл			10,842,282,684.87	10,842,282,684.87
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			(2,070,839,858.34)	(2,070,839,858.34)
5	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл			(12,913,122,543.21)	(12,913,122,543.21)
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			124,495,126.66	124,495,126.66
7	Залруулсан үлдэгдэл			(12,788,627,416.55)	(12,788,627,416.55)
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(6,474,353,202.73)	(6,474,353,202.73)
9	Бусад дэлгэрэнгүй орлого		18,635,520,000		18,635,520,000.00
10	Өмчид гарсан өөрчлөлт	20,000			
	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	20,000	18,635,520,000	(19,262,980,619.28)	(627,440,619.28)

#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	5,149,687.00	15,262,401.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,130,000.00	
1.1.2	Буцаан авсан албан татвар	3,010,357.00	
1.1.3	Татаас, санхүүжилтийн орлого	838,400.00	
1.1.4	Бусад мөнгөн орлого	170,930.00	15,262,401.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	791,906,350.68	1,485,809,595.68
1.2.1	Ажиллагчдад төлсөн	391,460,166.31	697,324,967.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	89,148,716.76	164,057,224.58
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	87,318,621.20	23,270,943.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	113,146,812.80	359,788,322.49
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	18,731,297.00	38,804,254.64
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	26,108,292.05	98,680,102.71
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн		3,436,590.00
1.2.8	Бусад мөнгөн зарлага	65,992,444.56	100,447,191.04
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>786,756,663.68</b>	<b>1,470,547,194.68</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	3,619,699.98	12,234,597.28
2.1.1	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	167,723.20	4,772,100.00
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого	3,451,976.78	7,462,497.28
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	108,532,605.40	42,495,325.24
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,090,800.00	40,617,400.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,500,000.00	
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	100,941,805.40	1,877,925.24
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(104,912,905.42)</b>	<b>(30,260,727.96)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	1,016,587,517.08	1,926,712,144.21
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,016,587,517.08	1,926,712,144.21
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	0,00	0,00

<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,016,587,517.08</b>	<b>1,926,712,144.21</b>
<b>4</b>	Валютын ханшийн зөрүү	(3,873,794.83)	(2,817,005.07)
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>121,044,153.15</b>	<b>423,087,216.50</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>44,361,431.11</b>	<b>165,405,584.26</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>165,405,584.26</b>	<b>588,492,800.76</b>

#### 4.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон  
(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1.	<b>Нийт орлого</b>	<b>8,500.00</b>	<b>7,462.50</b>	<b>1,037.50</b>
2.	<b>Нийт зардал</b>	<b>3,183,799.2</b>	<b>1,508,315.40</b>	<b>1,675,483.80</b>
3.	Урсгал зардал	1,512,785.20	1,429,822.90	82,962.30
4.	Цэвэр ашиг (алдагдал)	(5,731,670.30)	(6,474,353.20)	(742,682.90)
5.	<b>Хөрөнгө оруулалтын зардал</b>	<b>35,000.00</b>	<b>34,911.40</b>	<b>88.60</b>
6.	<b>Зөвлөх үйлчилгээний зардал</b>	<b>1,500,000.00</b>		<b>1,500,000.00</b>
7.	<b>Дотоод байгууллагын өглөг</b>	<b>136,014.00</b>	<b>43,581.10</b>	<b>92,432.90</b>
8.	<b>Нийт авлага</b>	<b>850.00</b>	<b>850.00</b>	<b>-</b>
9.	<b>Нийт өглөг</b>	<b>30,182,162.90</b>	<b>31,406,874.70</b>	<b>(1,224,711.80)</b>
10.	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	3,158,675.70	93,059.00	3,065,616.70
11.	Урт хугацаат өр төлбөр	27,023,487.20	31,313,815.70	(4,290,328.50)
12.	Нийт ажиллагсдын тоо	28	28	-
13.	Нийт цалингийн сан	1,017,408.00	961,397.10	56,010.90
	Нэг ажиллагчийн дундаж цалин	2,399.80	2,861.30	(461.50)

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	2018	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>Аудитын код:</b>	САГ-2019/94/СТА-ТӨҮГ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	“Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК			<b>Сая төгрөгөөр</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	“Вивид технологи” ХХК-тай холбоотой 15.0 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй.	15.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Отгонсүх М.Лхагвасүрэн
2	Жилийн эцэст 66.5 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй, тооллого үйлдээгүй, кассын үлдэгдлийн дээд хэмжээг баталж мөрдөөгүй.	66.5	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Б.Отгонсүх М.Лхагвасүрэн
3	Томилолтын зам хоногийн зардал хэтрүүлсэн.	1.5	Төлбөрийн акт	Захирал Нягтлан бодогч	Б.Отгонсүх М.Лхагвасүрэн
4	Принтерийн хор худалдан авсан гэх 1.0 сая төгрөгийн хүчин төгөлдөр бус баримттай гүйлгээг бүртгэсэн.	1.0	Төлбөрийн акт	Захирал Нягтлан бодогч	Б.Отгонсүх М.Лхагвасүрэн
5	Мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгээгүй, 34.5 сая төгрөгийн томилолтын урьдчилгааны тооцоо хийгээгүй.	34.5	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Б.Отгонсүх М.Лхагвасүрэн
6	- Нягтлан бодогч нь бэлэн мөнгөний нярвын ажлыг хавсарсан. - Мөнгө хүлээн авсан, өргөдөл гаргасан хүний гарын үсэггүй 10.7 сая төгрөгийн баримтыг санхүүгийн тайланд тусгасан.	45.2	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Отгонсүх М.Лхагвасүрэн
<b>Дүн</b>		<b>129.2</b>			





